



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/123

Хархорин сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 3 дугаар баг Арцат 10-31 тоотод байрлах 6209000381 нэгж талбарын 711 м² газрыг Банзарын Жанчивдоржийн хүсэлтийн дагуу Батбаярын Пүрэв-Очирт шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч Батбаярын Пүрэв-Очирт газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Ч.Баттулга), (Э.Дэнсмаа) нарт даалгасугай.

3.Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2003 оны А/63 дугаар захирамж, газар эзэмших эрхийн 0000295935 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

401100245